

ПАТРОНАЖ ТОМИЛГОО БА УЛС ТӨРИЙН ДЭГЛЭМИЙН ӨӨРЧЛӨЛТ

Ц. Батболд

Улс төр судлалын тэнхимийн доктор (Ph. D.), дэд профессор

Монгол улсын их сургууль

Шинжлэх ухааны сургууль

batbold_ts@num.edu.mn

Н. Отгонбаяр

Улс төр судлалын тэнхимийн докторант

Монгол улсын их сургууль

Шинжлэх ухааны сургууль

otgonbayar.n@etugen.edu.mn

Abstract: *Since the post-Cold War era, researchers have focused on patronage appointment as an informal form of political communication in social life. There is a reason for this. Establishment of patronage appointments in the civil service, this has an impact on the activities of political parties, including ruling, and in developing countries there is a tendency to change the fundamental nature of the political regime.*

In this article, researchers tried to consider patronage appointments in the civil service and its impact on the fundamental characteristics of the political regime.

Key words: *patronage appointment, political party, and political regime.*

УДИРТГАЛ

Хүйтэн дайны дараах үеэс хөгжиж буй улс орнуудад тоталитари юм уу авторитари дэглэмээс ардчилсан улс төрийн дэглэмд шилжих үйл явц эрчимжсэн. Үүнийг гадна, дотны судлаачид “ардчилах үйл явцын гурав дахь давалгаа”-тай холбон тайлбарлах [11, 12-34; 1] юм уу, “үзэл санааны хувьсал эцэс” болж, “засаглалын сүүлчийн хэлбэр болохын хувьд либерал ардчилал түгээмэл шинжтэй болж буй илрэл” мөн гэж үзэцгээх болсон [8, 3-16]. Гэвч үүний зэрэгцээ дээрх орнууд нийгэм, эдийн засгийн шинжтэй хүндхэн асуудлыг шийдвэрлэх томоохон сорилттай тулгарч, үүнийг шийдвэрлэж чадаагүй олонх нь улс төрийн хувьд завсрын шинжтэй дэглэмд шилжсэн. Өөрөөр хэлбэл, нэг талаас, ардчилсан дэглэмийн зарим нэг шинжийг, нөгөө талаас, авторитари дэглэмийн удирдлагын арга барилтай хослуулсан холимог буюу завсрын дэглэм бий болжээ. Эдгээрийг

бүрэн хэмжээний авторитари юм уу ардчилсан дэглэмээс зааглан үзэх хэрэгтэй.

Хэдийгээр “хагас ардчилсан”, “сонгуульт ардчилсан”, “хуурамч ардчилсан” гэх мэт янз бүрийн ойлголтоор тодотгон нэрлэж болох ч үүсэж бий болсон үзэгдэл, үйл явцыг бүрэн дүүрэн тайлбарлахад учир дутагдалтай байна. Стивэн Лэвицки, Люсин А. Уэй (Levitsky and Way) нарын судалснаар, хөгжиж буй орнуудад болж буй үзэгдэл, үйл явцыг бүхэлд ардчилсан өөрчлөлтийн дор халхавчлан авч үзэх нь *нэгт*, урт удаан хугацааны туршид ардчилалд шилжиж буй гэх, *хоёрт*, ардчиллын гажуудсан хэлбэрийг бий болгосон гэх хуурмаг дүгнэлтэд тус тус хүргэдэг байна. Ингэснээр улс төрийн үзэгдлийн жинхэнэ мөн чанарыг танин мэдэх, ойлгох бололцоо муу олгодог байна [18, 52,53]. Үүнтэй зэрэгцээд судлаач Жэффри Хэрбст (Herbst), Томас Карозэрс (Carothers) нарын үзсэнээр, хөгжиж буй орнуудын ихэнх нь нийгэм-эдийн засгийн хурцадмал асуудлаа шийдвэрлэж чадаагүйн улмаас авторитари арга барил давамгайлсан завсрын дэглэмд шилжсэн гэжээ [10, 357-75; 7, 5-21].

Өгүүллийн хүрээнд судлаачид патронаж томилгоо ба улс төрийн дэглэм хоорондын харилцааны асуудлыг авч үзэхийг оролдсон болно. Тус өгүүлэл бүтцийн хувьд удиртгал, онолын судалгааны үр дүн, дүгнэлт гэсэн гурван хэсгээс бүрдэнэ.

ОНОЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Патронаж томилгоо

Улс төрийн үзэгдэл, үйл явц болохын хувьд патронаж нь эртний Грек-Ромд анхлан бий болсон түүхтэй. Харилцан ашигтай байхыг гол зарчмаа болгосон нийгмийн тэгш бус харилцааг уг ойлголтоор дамжуулан илэрхийлж байсан. Эд баялаг, нэр хүнд, эрх мэдэл бүхий патрон, улс төрийн дэмжлэг, туслалцаа үзүүлж, засаглалын легитим байдлыг хангах, хариуд нь эд материалын дэмжлэг эрэлхийлэх клиент нар уг харилцааны агуулгыг тодорхойлдог байна [14, 117].

Улс төрийн шинжлэх ухаанд ХХ зууны 50, 60-аад оны үеэс бие даасан судлагдахуун хэлбэрээр идэвхтэй ашиглагдах болсон [4, 66]. Нэршлийн хувьд “патронаж” /patronage/, “улс төрийн патронаж” /political patronage/, “намын патронаж” /party patronage/, “патрон-клиентийн харилцаа” /patron-client relations/, “патронаж томилгоо” /patronage appointment/ гэх мэт олон янз байдлаар ойлгож байна.

Орчин үеийн улс төрийн судалгаанд юуны түрүүнд, патронаж томилгоог эрх баригч нам, хүчний зүгээс эрх мэдэл, нөөцийг үр дүнтэй хуваарилах, тогтоон барих арга, хэрэгслийн нэг мөн гэж үздэг [19]. Үүнээс гадна, уг үзэгдлийг олон янз байдлаар тодорхойлж байна. Зарим

судлаачдын зүгээс, патронаж томилгоог хоёр [9] юм уу гурван үндсэн хандлагын хүрээнд [6] авч үзэж судлах бололцоотой гэсэн санааг илэрхийлдэг.

Орчин үеийн улс төрийн судалгаанд патронаж томилгоог хүн амын амьдралын чанар, эдийн засгийн өсөлт, хөгжил, боловсролын хүртээмж гэх мэт нийгэм, эдийн засгийн хүчин зүйлтэй холбон тайлбарлах улс төрийн эдийн засгийн /political economy/, улс төрийн нам, хүчнүүдийн хоорондын харилцаа, тэдгээрийн мөн чанартай холбон судлах улс төрийн /political/, соёлын ялгамж, улс төрийн харилцааны хоцрогдмол байдалтай холбох соёлын /cultural/, нийгмийн дотоодод мөрдөгдөж буй хэм хэмжээ, дүрэм журмын нийлбэр цогцоор төлөөлүүлэн судлах институционал /institutional/ гэх дөрвөн хандлага байна гэж үзэж болох талтай. /Зураг 1-ийг үзнэ үү/.

Зураг 1. Патронаж томилгооны талаарх онолын хандлагууд



Эх сурвалж: Судлаач боловсруулсан.

Патронаж томилгоо гэдгийг судлаачид олон янзаар тодорхойлсон байдаг ч нийтлэг шинж чанарт үндэслэн дараах байдлаар авч үзэж болох байна. Патронаж томилгоо гэдэг нь шийдвэр хуульд нийцсэн, үгүйгээс үл хамааран эрх баригч нам, улс төрчдийн зүгээс гишүүн, дэмжигчдээ мэдлэг чадвар, мэргэшил, туршлага шаардах төрийн албан тушаалд үнэнч байдлыг шалгуур болгон томилох, юм уу уг шалгуурыг удирдлага болгон төрийн албан хаагчдыг албан тушаалаас халах, чөлөөлөх үйл явцтай хамаарал бүхий патрон, клиентийн хоёр талт харилцаа мөн [4, 72]. Монгол хэлнээ патронаж томилгоо гэх ойлголтыг сүүлийн үеийн судалгааны бүтээлүүдэд “ивээл, хамгааллын бодлого”, “улс төрийн ивгээлийн томилгоо” гэхчлэн орчуулан хэрэглэж байна [2, 106; 3, 72].

Мөн хоёр зүйлийг онцгойлон анхаарах шаардлага гарна. *Нэгдүгээрт*, патронаж томилгоо нь клиентелизм гэх нийгмийн өргөн хүрээтэй харилцааны нэг хэлбэр болно [13]. *Хоёрдугаарт*, төрийн албан хаагчийг улс төрийн хэмжүүрийг удирдлага болгон томилж, чөлөөлөх, халах үйл явцыг цогцоор илэрхийлсэн үзэгдэл юм. Энэ талаас авч үзвэл

клиентелист харилцааны нэгэн адил патронаж томилгоо дараах үндсэн шинжийг өөртөө агуулдаг гэж үзэж болно /Зураг 2-ыг үзнэ үү/.

Зураг 2. Патронаж томилгооны үндсэн шинжүүд



Эх сурвалж: [15, 43-46; 20, 3]

Судлаач Виржиния Оливэрис (Oliveris)-ийн үзсэнээр, патронаж томилгоо өөрөө өөрийгөө тэтгэн өргөжүүлэх хандлагатай /Self-enforcing theory/ байдаг бөгөөд эрх мэдэл, албан тушаалаа алдахаас эмээсэн патрон, клиентийн айдас онцгой нөлөө үзүүлдэг байна [13, 24-52].

Патронаж томилгооны улс төрийн дэглэмд үзүүлэх нөлөө

Патронаж томилгооны нийгмийн харилцаанд үзүүлэх үр нөлөөний асуудлаар судлаачид харилцан адилгүй байр суурь илэрхийлдэг. Тэдгээрийн нэг нь улс төрийн дэглэмийн суурь шинжид өөрчлөлт оруулдаг гэх тайлбар юм [6, 150]. Өөрөөр хэлбэл, патронаж томилгоо улс төрийн ардчилсан дэглэмээс авторитари удирдлагын арга барил давамгайлсан завсрын дэглэм тогтоход нөлөөлдөг байна. Үүнийг Харвардын Их Сургуулийн профессор Стивэн Лэвицки, Торонто Их Сургуулийн судлаач Люсин А. Уэй (Levitsky and Way) нар “өрсөлдөөнт авторитаризм” хэмээн нэрлэжээ. Тэдний үзсэнээр улс төрийн ардчилсан дэглэм

1. Гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийг бүх нийтийн, нээлттэй, чөлөөт, шударга сонгуулиар байгуулдаг;
2. Иргэн бүр сонгох, сонгогдох эрхтэй байдаг;
3. Хүн бүрийн хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх зэрэг иргэний болон улс төрийн эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрдөг;
4. Сонгож байгуулсан засаг улс орныг удирдах бодит эрхийг атгадаг гэх дөрвөн шинжид тулгуурладаг байна [18].

Гэвч эрх баригч намуудын үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналт суларснаар төрийн нөөцийг намын эрх ашигт захируулан хуваарилах, намд үнэнч хүмүүсээр /гишүүн, дэмжигчид/ төрийн албыг

бүрдүүлэх үйл явц эрчимждэг байна. Өөрөөр хэлбэл, эрх баригч намд үнэнч байх нь нөөцийн хуваарилалтад оролцох, төрийн албанд орох боломжийг нээж өгдөг гэсэн үг юм. Үр дүнд нь улс төрийн өрсөлдөөн хязгаарлагдах, засаглалын ил тод байдал алдагдах, иргэдийн улс төрийн болон иргэний эрх, эрх чөлөө хаагдах, ардчилсан институтуудыг ардчилсан бус зорилгоор ашиглах байдал бий болно. Эдгээр нь юуны түрүүнд, өрсөлдөөнт авторитари дэглэм тогтох урьдач нөхцөл болдог байна [17; 12].

Дээрхтэй төстэй санааг Төв Европын Их Сургуулийн профессор Андреас Шэдлер (Schedler) бүтээлдээ хөгжүүлсэн байна. Гэхдээ Лэвицки, Уэй нараас ялгаатай нь, “сонгуульт авторитаризм” гэх ойлголтоор дамжуулан дээрх үйл явцыг авч үзсэн. Сонгуулийн үйл явцыг авторитари удирдлагын арга барилтай хослуулсан өвөрмөц дэглэм болохыг гаргасан. Мөн удирдлагад үнэнч байх явдал сонгуульт авторитари дэглэмийн суурь шинж болохыг онцолсон. Өөрөөр хэлбэл, төрийн албанд орох, баялаг хуваарилалтад оролцох үндсэн шалгуур нь удирдлагад үнэнч байх явдал болно [16]. Эндээс патронаж томилгоог системтэйгээр дэмждэг гэсэн санаа гарч байна.

ДҮГНЭЛТ

Өгүүллийн хүрээнд дараах санааг дүгнэлт болгон гаргаж болох байна. Эдгээрт:

1. Патронаж томилгоог авч үзэх, судлах нэгдсэн байр суурь өнөөг хүртэл төлөвшиж чадаагүй байна. Орчин үед патронаж томилгоог авч үзэх соёлын, улс төрийн, улс төрийн эдийн засгийн, институционал гэх дөрвөн үндсэн хандлага оршин байна.

2. Төрийн албанд эрх баригч нам, улс төрчдийн зүгээс үнэнч байдлыг шалгуур болгон төрийн албанд гишүүн, дэмжигчдээ томилох, тэрчлэн төрийн албанаас албан хаагчийг чөлөөлөх, халах үйл явцыг “патронаж” /patronage/, “улс төрийн патронаж” /political patronage/, “намын патронаж” /party patronage/, “патрон-клиэнтийн харилцаа” /patron-client relations/, “патронаж томилгоо” /patronage appointment/ гэхчлэн олон янз байдлаар нэрлэж байна.

3. Патронаж томилгоо төрийн албанд төдийгүй дэглэмийн суурь шинжид хүртэл нөлөөлөл үзүүлдэг. Ингэснээр нэг талаас ардчилсан, нөгөө талаас, авторитари шинж чанарыг хослуулсан холимог хэлбэрийн дэглэм тогтдог байна.

НОМ ЗҮЙ

- [1]. Ганбат, Д. 2002. Монгол дахь ардчиллын хөгжлийн онол, арга зүйн асуудалд. Улс төрийн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл, УБ: МУИС, ШУС
- [2]. Конрад Аденауэр сан. 2021. Монголын ардчилал: Төлөөллийн ардчиллын сорилт ба шууд ардчиллын боломж. Edited by Ш. Батсүх. Судалгааны тайлан, Улаанбаатар хот
- [3]. Зүмбэрэлхам, Д. 2020. "Чадахуйн зарчим ба төрийн албаны хууль тогтоомжийн шинэтгэл." In Төрийн албаны шинэтгэл: Гарын авлага, 71-78. Улаанбаатар хот
- [4]. Т. Төмөр, Н. Отгонбаяр. 2023. "Патронаж томилгооны талаарх ойлголт, онолын хандлагууд." Төрийн удирдлага онол, арга зүйн сэтгүүл (№22)
- [5]. Б. Эрдэнэдалай, Г. Мөнхтуяа. 2023. ""Неопатримониал" онолын ойлголтыг тайлбарлах нь." Политологи сэтгүүл (№21 (571))
- [6]. Гилев, Алексей. 2016. "Введение. Черные кошки в темных комнатах: Исследования политического патронажа в общественных и гуманитарных науках." In Патрон-клиентские отношения в истории и современности: Хрестоматия, edited by Алексей Гилев, 6-40. Москва: РОССПЭН
- [7]. Carothers, Thomas. 2002. "The End of the Transition Paradigm." *Journal of Democracy* 13
- [8]. Fukuyama, Francis. 1989. "The End of History?" *The National Interest* 16
- [9]. Herbert Kitschelt and Steven Wilkinson. 2007. "Citizen-politician linkages." In *Patrons, Clients and Policies. Patterns of Democratic Accountability and Political Competition*, edited by Herbert Kitschelt and Steven Wilkinson, 1-49. Cambridge: Cambridge University Press
- [10]. Herbst, Jeffrey. 2001. "Political Liberalization in Africa after Ten Years." *Comparative Politics* 33
- [11]. Huntington, Samuel P. 1991. "Democracy's third wave." *Journal of Democracy* Vol. 2 (No 2)
- [12]. Loughlin, Neil. 2020. "Reassessing Cambodia's Patronage System(s) and the End of Competitive Authoritarianism: Electoral Clientelism in the Shadow of Coercion." *Pacific Affairs* Vol. 93 (Number 3)
- [13]. Oliveros, Virginia. 2021. *Patronage at work; Public jobs and Political Services in Argentina*. New York : Cambridge University Press
- [14]. Quinn, Kenneth. 1982. "Poet and Audience in the Augustan Age." *Aufstieg und Niedergang der römischen Welt* Vol. 30 (No 1)
- [15]. S. Eisensdadt, and L. Roniger. 1980. "Patron-Client Relations as a Model of Structuring Social Exchange." *Comparative Studies in Society and History* 22 (1)
- [16]. Schedler, Andreas. 2006. "The Logic of Electoral Authoritarianism." In *Electoral Authoritarianism: The Dynamics of Unfree Competition*, edited by Andreas Schedler, 1-23. Boulder, CO: Lynne Rienner
- [17]. Shafi M. D. Mostofa and D. B. Subedi. 2020. "Rise of Competitive Authoritarianism." *Politics and Religion* Vol. 14 (No 3)
- [18]. Steven Levitsky, and Lucian A. Way. 2002. "Elections Without Democracy: The Rise of Competitive Authoritarianism." *Journal of Democracy* Vol. 13 (No 2)
- [19]. Toral, Guillermo. 2020. *The Political Logics of Patronage: Uses and Abuses of Government Jobs in Brazil*. Submitted to the Department of Political Science in partial fulfillment of the requirements for the degree of Doctor of Philosophy in Political Science, Massachusetts: Massachusetts Institute of Technology
- [20]. Wolfgang Muno. 2010. *Conceptualizing and Measuring Clientelism*. Hamburg : Paper to be presented at the workshop „Neopatrimonialism in Various World Regions“ 23. August 2010, GIGA German Institute of Global and Area Studies